



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 4/22

Есөнбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1, 50.1.1 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь заалт, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/100 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх "Төгрөг соёлын төвийн засварын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Л.Ганхуяг	("Орон нутгийн өмчийн газрын дарга)
Гишүүд	Ж.Мөнхцэцэг	(Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл) (тохиролцсон)
Нарийн бичгийн дарга:	Н.Алгирмаа	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Л.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

